



Мүраками Харүки

Дэлхийд хамгийн их нэрд гарсан Япон зохиолч Мүраками Харүки 1949 оны 1-р сарын 12-нд Киотод төржээ. Тэрээр багаасаа уран зохиолд дурлаж, Густав Флобер, Чарльз Диккенс, Курт Воннегут, Ричард Бротиган, Жек Керуак зэрэг Америк, Европын зохиолчдыг шимтэн уншдаг байв. Мүраками анх 29 настайгаасаа зөгнөлт зохиол бичиж эхэлсэн бөгөөд 1978 оны дөрөвдүгээр сарын нэгэн өдөр бейсболын тэмцээн үзэж суухдаа анхныхаа романыг бичих санааг олсон бөгөөд тэр оройдоо л бичиж эхэлсэн гэдэг. Ийнхүү 10 сарын турш тууштай бичиж дуусгасан “Салхины дууллыг сонсохуй” роман нь утга зохиолын уралдаанд шалгарч, 1979 онд хэвлэгдсэн нь зохиолчид маш их урам зориг өгсөн бөгөөд жилийн дараа цуврал болгож “Пинбол 1973”, “Хонь ангуучилсан нь” романаа 1982 онд бичжээ. 1987 онд хэвлэгдсэн “Норвегийн ой” роман нь Мүракамыг алдар хүндийн оргилд хөтөлсөн бөгөөд олон сая хувь борлогдож, түүнийг дэлхийд танигдсан зохиолч болох замыг нь нээж өгчээ. Мөн тэрээр “Бүж, бүж, бүж”, “1Q84” цуврал роман, “Гүйлтийн тухай ярихдаа би юу хэлэв” зэрэг олон ном бичиж хэвлүүлсэн нь уншигчдын сэтгэлийг татсаар байна. Мүраками зохиол бичихээс гадна Фрэнсис Скотт Фицджеральд, Труман Капоте, Жон Ирвинг, Ж.Сэлинджерийн зохиолуудыг англи хэлнээс япон хэл рүү орчуулсан юм. Мүраками 1979 онд Кунзогийн нэрэмжит шагнал, 1982 онд Номагийн утга зохиолын шагнал, 1985 онд Танизакигийн нэрэмжит зэрэг нэр хүндтэй олон шагнал хүртсэнээс гадна 2008 онд Туфтс, 2014 онд Принстоны их сургуулиас хүндэт докторын зэрэг олгох хүсэлт тавьж байжээ. Мөн Нобелийн утга зохиолын салбарын шагналд хэдэнтээ нэр дэвшсэн боловч хараахан хүртээгүй байгаа бөгөөд энэ тухайгаа “Надад ямар ч шагнал хэрэггүй, шагнал авна гэдэг чинь чи дуусаж байна гэсэн үг” гэж инээмсэглэн хэлсэн гэдэг. Алдарт зохиолч маань өглөө 4 цагт босоод 6 цаг тасралтгүй зохиол бүтээлээ бичсэний дараа гүйх, усанд сэлэх, хөгжим сонсох зэргээр өдрийг өнгөрүүлээд оройн 9 цагаас дахин бүтээлээ туурвиж эхэлдэг агаад пянз цуглуулах нь түүний хобби ажээ.



Норвегийн ой


Зохиолч: [М.Харуки](#)

Формат: Зөөлөн хавтастай

Ангилал: [Хайр дурлал, романтик](#)

Агуулга

Японы орчин үеийн уран зохиолын онцгой нэгэн төлөөлөгч бол яахын арагуй Харуки Мураками юм. "Норвегийн ой" хэмээх роман нь гарсан даруйдаа Муракамиг дэлхий дахинаа алдаршуулж, зөвхөн Японд л гэхэд хоёр сая хувь борлогдож, түүний эл номыг тавиуртай залаагүй сэхээтэн гэр бүл байгаагүй гэлцдэг. Энэ зохиолд амьдралд хөл тавьсан нэгэн залуугийн амьдрал, хайр сэтгэл болоод хүмүүний нандин харилцааны тухай өгүүлнэ.



Зохиолч: М.Итгэл

Агуулга

Эрчимтэй сэтгэлгээний нийгэм рүү тэмүүлж буй өнөө үед ямар ч насны хүн оюун

сэтгэлгээгээ хурцалж байх учиртай. Бидэнд тохиолдсон хүнд, маргаантай асуудлыг


гагцхүү оюунаа дасгалжуулсан хүн л хамгийн зөв хувилбараар шийдэх нь гарцаагүй.

Сэтгэхүйн сэлгээ, хөрвөлт хийх дасгалд бүхэлдээ чиглэгдсэн төрөл бүрийн 100 бодлогыг

багтаасан энэ ном та бүхнийг оюунаа хөгжүүлэх, тэдгээрийн үндсэн ойлголтуудтай

танилцуулах өргөн боломжийг олгож байна. Бодлого бүрт дөхүүлэх "заавар", "бодолт",

"хариу", шог хошин зураглал бий.



[Бүрэнхий \(Бүрэнхий \)](#)

Зохиолч: [С.Мэйер](#)

Агуулга

Изабелла Свон уйтгартай Форкс хот руу нүүн оньсого мэт, сэтгэл татам Эдвард Каллентай учрах үед түүний амьдрал сэтгэл догдлол, айдсаар дүүрэн болов. Цав цагаан царай, алтлаг нүд, мартагдашгүй хоолой болон ер бусын чадвартай Эдвард тайлагдашгүй нууцлаг агаад соронз мэт татах ажээ. Өдийг хүртэл тэрээр өөрийн үнэн дүр төрхийг нууцалсаар ирж чадсан боловч Белла түүний харанхуй нууцыг нээхээр сэтгэл шулууджээ.

Түүнд хэдий чинээ ойртоно төдий чинээ өөрийгөө болон ойр тойрныхоо хүмүүсийг эрсдэлд оруулж байгаагаа харин Белла ухаарсангүй. Одоо эргэж буцахад дэндүү оройтсон байж болох юм. Сонирхлыг гүнээ төрүүлэх ер бусын сэтгэл татам *Бүрэнхий* хэмээх энэ ном төгсгөлийн хуудас хүртлээ уншигчдын зүрх сэтгэлийг догдлуулах болно.



Зохиолч: [С.Мэйер](#)

Агуулга

Белла Свонд амьдралаасаа ч эрхэмд үздэг нэг зүйл бий. Тэр бол Эдвард Каллен. Гэвч цус сорогчид хайртай болно гэдэг өөрийнх нь төсөөллөөс ч илүү аюултай ажээ. Хэдийгээр Эдвард хорон санаат цус сорогчийн савраас Беллаг аварсан ч, энэ нь саад бэрхшээлийн дөнгөж эхлэл болохыг хэн хэн нь ухаарсан юм. Тэдний зоримог, аз сорьсон сэтгэлийн харилцаа нь өөрсдөд нь хийгээд ойр тойрных нь бүх хүнд аюул заналхийллийг, даллаж байв. Сэтгэл хөдлөлөөр дүүрэн, салахын аргагүй, санаанд оромгүй эргэлт, ээдрээт өрнөл үйл явдалтай энэхүү цуврал нь утга зохиолын мөнхийн бүтээл болж чаджээ.


Брий Таннерын хоёр дахь амьдрал (Бүрэнхий)

Зохиолч: [С.Мэйер](#)

Агуулга

Хиртэлт романд анх цухасхан дүрслэгддэг Брий Таннерын энэ түүх болон шинэ цус сорогчдын аймшигт бараан ертөнц бүрэнхий цувралын хорхойтнуудын сэтгэлийг эзэмдэх нь гарцаагүй биз ээ. Дийлдэшгүй хүч, соргог мэдрэхүй, хариу үйлдэл үзүүлэх эгэлгүй чадвартай болохоос урьдах, цусанд хэзээ ч ханаж цадахгүй цус сорогчид хувирахаас өмнөх амьдралаа Брий бүдэг бадаг төдий санах ажээ. Брий, Диего хэмээх залуутай танилцаж, нөхөрлөнө. Тэдний хэн хэн нь нэрийг нь ч үл мэдэх, өөрсдийг нь бүтээгч тэр нэг эмэгтэйн талаар мэдэхийг хүсдэг. Улмаар шинэ төрөгсөд бол ердөө л шатрын хүү болохыг тэд ойлгож, хэнд итгэхээ шийдэхэд хүрнэ. Гэвч цус сорогчийн амьдрал худал ярих дээр тогтох тул үнэнийг хаанаас хайх билээ? Белла болон Каллены гэр бүлтэй тулалдахаар бэлтгэж, өөрсдийн үхэл рүү ойртож буй шинээр төрөгсдийн армийн тухай өгүүлэх, аюул, занал, нууцлаг үйл явдал, хайр дурлал сүлэлдсэн сэтгэл догдлом түүхийг Стефени Мэйер дэлгэж байна.





[Хиртэлт \(Бүрэнхий\)](#)

Зохиолч: [С.Мэйер](#)

Агуулга

Сеатлд цуврал хүн амины хэрэг гарч, золбин цус сорогч өш санасан хэвээр байгаа болохоор Беллад дахиад аюулд учирсан нь тодорхой болов. Дээр нь, тэр одоо цус сорогч, хүн чоно хоёрын мөнхийн зөрчилдөөнийг дэвэргэх чадалтайг мэдсээр байгаа ч, Эдвардад өгсөн хайр уу, Жейкобтой тогтоосон нөхөрлөл үү гэдэг чухал сонголтыг нэгмөсөн хийх шаардлагатай болсон. Удахгүй төгсөх гэж байгаа болохоор дахиад нэг сонголттой тулгарна. Амьдрал уу. Үхэл үү. Гэхдээ аль нь юу билээ? "Бүрэнхий", "Шинэ сар" хоёрт шимтсэн уншигчдад удаан хүлээлгэсэн Стефени Мэйерийн цус сорогчийн хайрын тухай цувралын гурав дахь нь болох *Хиртэлт* таалагдах нь гарцаагүй.